

**НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС,  
МОНГОЛ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
УДИРДЛАГЫН ТОХИРОЛЦОО**

Прага хотноо 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдөр гарын үсэг зурсан “Нийгмийн хамгааллын тухай Бүгд Найрамдах Чех Улс болон Монгол Улс хоорондын хэлэлцээр (цаашид “Хэлэлцээр” гэх)-ийн 16 дугаар зүйлийн дагуу Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээдүүд дараах зүйлсийг харилцан тохиролцов:

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

**1 дүгээр зүйл  
Нэр томьёо**

Энэхүү Удирдлагын тохиролцоонд хэрэглэсэн нэр томьёо нь Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд тодорхойлсон нэр томьёотой ижил утгатай байна.

**2 дугаар зүйл  
Эрх бүхий байгууллагууд**

Хэлэлцээрийн хэрэгжилтийг дараах эрх бүхий байгууллагууд хариуцна. Үүнд:

- I. Монгол Улсын тухайд:  
Нийгмийн даатгалын ерөнхий газар, түүний орон нутгийн хэлтэс;
- II. Бүгд Найрамдах Чех Улсын тухайд:
  - а) Чехийн Нийгмийн хамгааллын газар болон түүний орон нутаг дахь салбарууд;
  - б) Цэргийн хүчний байгууллагын нийгмийн хамгаалал хариуцсан алба.

**3 дугаар зүйл  
Харилцагч байгууллагууд**

1. Хэлэлцээрийн 16 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу харилцагч байгууллагууд нь:

- а) Монгол Улсын тухайд: Нийгмийн даатгалын ерөнхий газар;
- б) Бүгд Найрамдах Чех Улсын тухайд: Чехийн Нийгмийн хамгааллын газар.

2. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор харилцагч байгууллагууд харилцан нэгэндээ дэмжлэг үзүүлэхээс гадна хоорондоо болон хэлэлцээрийн 3 дугаар зүйлд заасан хүн болон байгууллага эсхүл тэдгээрийн төлөөлөлтэй шууд харилцана.

3. Харилцагч байгууллагууд нь Хэлэлцээр болон Удирдлагын тохиролцоог хэрэгжүүлэхэд шаардлагатай маягт болон нарийвчилсан журмыг харилцан тохиролцоно.

Тэтгэвэр авах өргөдөл, хүсэлт, гэрчилгээ болон бусад баримт бичгийг тохиролцсон маягтын дагуу ирүүлээгүй тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий байгууллага эсхүл харилцагч байгууллага хүлээж авахаас татгалзаж болно

**2 ДУГААР БҮЛЭГ**  
**ДААТГАЛЫН ТАЛААРХ ЗААЛТ**  
**4 дүгээр зүйл**  
**Хууль тогтоомжид хамаарах гэрчилгээ**

1.Хэлэлцээрийн 8-10 дугаар зүйлд заасан тохиолдлын тухайд ажилтан, түүний ажил олгогчийн эсхүл хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хүсэлтээр хууль тогтоомжийг мөрдлөг болгож буй Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллага нь уг хүн тухайн талын хууль тогтоомжид хамрагдаж буйг нотолсон гэрчилгээг олгоно.

2.Хууль тогтоомжид хамаарах гэрчилгээ гаргасан эрх бүхий байгууллага нь гэрчилгээний хуулбарыг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

3.Хууль тогтоомжид хамаарах гэрчилгээ гаргуулсан хүн Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа гэрчилгээг хадгалах бөгөөд шаардлагатай тохиолдолд тухайн Хэлэлцэн тохиролцогч талын холбогдох байгууллагад хүргүүлнэ.

4.Хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн дагуу дараах онцгой тохиолдлыг тохиролцов.  
Үүнд:

а)Томилогдсон эрх бүхий байгууллагууд:

i.Монгол Улсын тухайд: Нийгмийн даатгалын ерөнхий газар;

ii.Бүгд Найрамдах Чех Улсын тухайд: Чехийн Нийгмийн хамгааллын газар.

б)Ажилтан, түүний ажил олгогч нь онцгой тохиолдлын талаарх хамтарсан хүсэлтийг өөрийн хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх Хэлэлцэн тохиролцогч талын томилсон эрх бүхий байгууллагад бичгээр хүргүүлнэ. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нь мөн ижил зарчмаар хүсэлтээ илгээнэ.

Хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасан хүн нь Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн үйлчлэлээс чөлөөлүүлэх хүсэлтээ томилолтын хугацаа дуусгавар болохоос өмнө мэдүүлнэ.

в)Онцгой тохиолдлын тухайд зөвшилцөлд хүрснийг энэ зүйлийн өмнөх заалтын дагуу гаргасан гэрчилгээ нотолно. .

**3 ДУГААР БҮЛЭГ**  
**ТЭТГЭВРИЙН ТАЛААРХ ЗҮЙЛ**  
**5 дугаар зүйл**  
**Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох**

Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий байгууллагууд өөрсдийн хууль тогтоомжийн хүрээнд тохиролцсон маягтын дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлно.

## **6 дугаар зүйл Монгол Улсын талын хариуцах асуудал**

1995 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл Бүгд Найрамдах Чех Улсад даатгалын шимтгэл төлсөн болон Хэлэлцээрийн 27 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд үнэлсэн хугацааг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөнөөр тооцно.

## **7 дугаар зүйл. Тэтгэвэр тогтоолгох өргөдөл**

1. Энэхүү хэлэлцээрийн дагуу тэтгэвэр тогтоолгох өргөдлийг оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллагад гаргахыг илүүд үзнэ.

2. Өргөдөл хүлээн авсан талын эрх бүхийн байгууллага нь шууд эсхүл харилцагч байгууллагаар дамжуулан өргөдлийг цаг алдалгүй Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагад хүргүүлнэ. Мөн тухайн талд даатгалын шимтгэл төлсөн тохиолдолд уг хугацааг баталгаажуулсан маягт болон тэтгэвэр тогтоолгох эрхийг тодорхойлоход шаардлагатай бусад баримт бичгүүдийг хүргүүлнэ.

3. Энэхүү зүйлийн 2 дугаар заалт дахь баримт бичгийг илгээхийн өмнө эрх бүхий байгууллага нь өргөдөл хүлээн авсан огноог тодорхой бичиж мөн өргөдөл гаргагчийн хувийн мэдээллийг нарийвчлан шалгаж, баталгаажуулна. Ийнхүү баталгаажуулснаар баримт бичгүүдийн эх хувийг илгээхгүй байж болно. Эдгээр баримт бичгүүдийг холбогдох маягтын дагуу бүрдүүлэх бөгөөд эргэлзээ гарсан тохиолдолд эх баримт бичгийг авах хүсэлт гаргаж болно.

4. Эрх бүхий байгууллагууд тэтгэвэр тогтоолгох эрхийг тодорхойлохтой холбоотой баримт, мэдээг харилцан мэдээлнэ.

## **8 дугаар зүйл. Шийдвэрийг мэдэгдэх**

Эрх бүхий байгууллага нь өргөдөл гаргагчийн эрхийг хэлэлцээрт заасны дагуу тодорхойлох бөгөөд шийдвэрийг өргөдөл гаргагчид мэдээлэхдээ авах арга хэмжээ болон давж заалдах сүүлийн хугацааг мөн мэдэгдэнэ. Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагад шийдвэрийн хувийг хүргүүлнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗААЛТ 9 дүгээр зүйл Мэдээлэл солилцох**

1. Хэлэлцэн тохиролцогч хоёр талын эрх бүхий байгууллагууд хоорондоо харилцан дэмжлэг үзүүлэх ба тэтгэвэр, тэтгэмж авах эрх тогтооход нөлөөлж болохуйц бүхий л мэдээллийг шууд буюу харилцагч байгууллагаар дамжуулан солилцоно. Тодруулбал:

- нас барах;
- бэлэвсэн эрэгтэй/эмэгтэй дахин гэрлэх;

- оршин суугаа хаяг өөрчлөгдөх;
  - Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэр эсхүл гуравдагч улс руу оршин суухаар шилжих;
  - тэтгэвэр тогтоох эрхийг хасах;
  - хамаарал бүхий хүний тоо өөрчлөгдөх;
  - Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ өөрчлөгдөх,
- болон Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад бүх шаардлагатай мэдээллүүд.

2. Харилцагч байгууллагууд нь хэлэлцээрийн дагуу тэтгэвэр тогтоолгох эрхэд нөлөөлөхүйц өөрчлөлт Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хууль тогтоомжид орсон тохиолдолд харилцан мэдээлнэ.

3. Харилцагч байгууллагууд нь эрх бүхий байгууллагуудын хооронд цахимаар мэдээлэл солилцохыг зөвшөөрч болно. Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хувьд цахимаар солилцсон баримт бичиг болон мэдээллүүд нь эрх зүйн хувьд адил хүчин төгөлдөр байна.

## **10 дугаар зүйл**

### **Эрүүл мэндийн мэдээллийг солилцох**

1. Тэтгэвэр тогтоолгохоор өргөдөл гаргах эсхүл тэтгэвэр олгоход эрүүл мэндийн үзлэгт хамрагдах шаардлага тавьдаг бол өргөдөл гаргагч эсхүл тэтгэвэр авагчийн байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллага нь өөрийн талын хууль тогтоомжийн дагуу эмнэлгийн үзлэгийг гүйцэтгэх бөгөөд тохиролцсон маягтын дагуу эрүүл мэндийн талаарх мэдээлэл болон чадвар алдалтын тухай бүх баримт бичгийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

2. Шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллага нэмэлт шинжилгээ өгөхийг хүсэж болно.

3. Эрх бүхий байгууллагууд нь өөрсдийн сонгосон эмчид хандан тухайн хүнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах эрхтэй.

## **11 дүгээр зүйл.**

### **Тэтгэвэр олгох**

1. Эрх бүхий байгууллагууд нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эсхүл гуравдагч улсын нутаг дэвсгэрт оршин суугаа тэтгэвэр авагчид холбогдох хуульд заасан хугацаа, журмын дагуу тэтгэврийг олгоно.

2. Тэтгэвэр авагч нь тэтгэврийг олгож буй Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллагад, тухайн талын хуулийн дагуу олгосон амьд болохыг баталсан баримт бичгийг шууд эсхүл харилцагч байгууллагаар дамжуулан хүргүүлэх үүрэг хүлээнэ.

## **12 дугаар зүйл.**

### **Илүү олгосон төлбөрийг шийдвэрлэх**

1. Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий байгууллагууд нь хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй илүү төлөлтийн асуудлаар зөвшилцөнө.

2. Хэрэв Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий байгууллага нь тэтгэврийг илүү олгосон бол, өөрийн хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, хязгаарын хүрээнд Хэлэлцэн

тохиролцогч нөгөө талын тэтгэврийг хариуцан олгож байгаа эрх бүхий байгууллагад хандан тэтгэвэр авагчид олгох тэтгэврээс илүү олгосон төлбөрийг суутгаж өгөх хүсэлтийг гаргаж болно. Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллага нь илүү төлөлтийг өөрөө олгосон мэтээр үзэж, мөрдлөг болгодог хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл болон хязгаарын хүрээнд илүү олгосон төлбөрийг суутгаж, илүү төлөлт хийсэн Хэлэлцэн тохиролцогч эхний талын эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

**13 дугаар зүйл.**  
**Илүү олгосон төлбөрийг сэргээн суутгах**

Энэхүү Удирдлагын тохиролцооны 12 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэх боломжгүй илүү олгосон төлөлтийг Хэлэлцэн тохиролцогч эхний талын холбогдох дүрэм журмын дагуу баталгаа, давуу эрхийг хэвээр хадгалж Хэлэлцэн тохиролцогч нөгөө талд сэргээн суутгаж болно.

**14 дүгээр зүйл**  
**Статистик мэдээлэл солилцох**

Хэлэлцээрийн дагуу тэтгэвэр авагчид олгосон тэтгэвэр болон хууль тогтоомжид хамаарах тухай гэрчилгээний талаарх жилийн эцсийн статистик мэдээллийг эрх бүхий байгууллагууд тохиролцсон маягтын дагуу харилцан солилцоно. Мэдээлэл солилцох маягтыг харилцагч байгууллагууд зөвшилцөн тохиролцоно.

**15 дүгээр зүйл.**  
**Хүчин төгөлдөр болох, үргэлжлэх хугацаа ба нэмэлт, өөрчлөлт**

Энэхүү Удирдлагын тохиролцоо нь хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба ижил хугацаанд хүчинтэй байна. Удирдлагын тохиролцоонд эрх бүхий этгээдүүд харилцан зөвшилцсөний үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулна.

Энэхүү Удирдлагын тохиролцоог ..... хотноо.... оны .....сарын .....өдөр чех, монгол, англи хэл дээр тус бүр 2 хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Орчуулгын зөрүү гарсан тохиолдолд англи эх бичвэрийг баримтална.

**БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛСЫН ЭРХ  
БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ ТӨЛӨӨЛЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЭРХ БҮХИЙ  
ЭТГЭЭДИЙГ ТӨЛӨӨЛЖ**